

УРЬДЧИЛСАН ТАЙЛАН Дугаар. 01
2013 оны 5 сарын 10-наас 6 сарын 3-ны өдрүүд

2013 оны 6 сарын 6-ны өдөр

I. ТОВЧ ХУРААНГУЙ

- 2013 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Монгол улсын ерөнхийлөгчийн сонгууль болно. Анхан шатны сонгуулиар нэр дэвшигчдийн хэн нь ч сонгогчдын олонхын санал аваагүй бол дахин санал хураалтыг 14 хоногийн дотор явуулна.
- Энэ удаагийн сонгуульд гурван нэр дэвшигч бүртгүүлсэн бөгөөд тэднийг зөвхөн УИХ-д суудалтай нам, улс төрийн намын эвслүүд нэр дэвшүүлэх эрхтэй юм. Ерөнхийлөгчийн сонгуульд хувь хүн бие даан нэр дэвшихгүй гэж заасан нь ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагены баримт бичгийн 7.5 зүйлд зааснаас ялгаатай байна.
- Уг сонгууль нь 2012 оны 12-р сард шинэчлэн баталсан Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай (МУЕСТХ) хуулийн дагуу явагдана. Шинэ хууль олон талаараа сайжирсан боловч хуульд тусгагдаагүй асуудал, тодорхойгүй заалт, сонгуулийн сурталчилгааны талаар хэт их хязгаарлалтууд байна.
- Сонгуулийг улсын хэмжээнд Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ), Аймаг, нийслэлийн сонгуулийн 22 хороо, Сум, дүүргийн сонгуулийн 330 хороо, 1,903 хэсгийн хороод тус тус зохион байгуулна. Бүх сонгуулийн хороонд төрийн албан хаагчид томилогдон ажиллаж байна. СЕХ нь хуулийн хугацаанд багтаан сонгуулийн бэлтгэл ажлыг жигдрүүлж буй хэдий ч сонгуулийн нэгж хороодод тохирох зохицуулалт хараахан хийгээгүй байна. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хорооныхонтой (САХ) уулзсан зарим хүмүүс сонгуулийн санал тоолох машинд итгэхгүй байгаагаа илэрхийлж байв.
- Одоогийн байдлаар 1.9 сая орчим сонгогчид бүртгүүлээд байна. 6 сарын 6-ны өдөр сонгогчдын нэрсийн жагсаалтыг олон нийтэд нээлттэй болгоно. Сонгогч бүр бүртгэлээ нягтлан үзэж, өөрийн бүртгэлд засвар хийх, сонгуулийн өөр тойрог руу нэрээ шилжүүлэх бол 6 сарын 16-ныг хүртэлх хугацаанд хүсэлтээ гаргана.
- 5 сарын 22-нд сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхэлж, 6 сарын 25-ны 00.00 цагт дуусна. МУЕСТХ нь нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг ерөнхийлөгчийн үүрэг хариуцлагын хүрээнд байхаар хязгаарласан тул сонгуулийн сурталчилгаа анхаарал бага татахуйц, тайван явагдаж байна.
- Сонгуулийн сурталчилгааг олон нийтийн радио, телевизээр тодорхой цагт үнэ төлбөргүй, бусад арилжааны телевиз, радиогоор зохих төлбөртэй нэвтрүүлэхийг МУЕСТХ-аар зохицуулжээ. Өргөн нэвтрүүлгийн хэрэгслээр нэвтрүүлж буй улс төрийн агуулгатай сурталчилгаанд эрх зүйн зохицуулалт хийсэн хэдий ч сонин хэвлэлээр сонгуулийн мэдээ, нийтлэл бичих талаар тодорхой заалт байхгүйгээс гадна мэдээллийн хөтөлбөрөөр сонгуулийн сурталчилгаа явуулж болох эсэхийг СЕХ албан ёсоор тайлбарлаагүй байна.

- Сонгуулийн хууль журмыг зөрчсөнтэй холбоотой гомдол, хүсэлтийг шийдвэрлэх эрх мэдэл бүхий ганц байгууллага бус хэд хэдэн Засгийн газрын болон шүүх цагдаагийн байгууллагууд байна. Сонгуулийн нэгж хэсгүүдээс илэрсэн зөрчлийг СЕХ дангаараа шийдвэрлэдэг бол бусад төрлийн гомдлыг цагдаагийн байгууллага судалж, шүүх рүү шилжүүлж байна. СЕХ-нд гаргасан хоёр гомдлыг хэрэгсэхгүй болгосон тухай мэдээлэл ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилсон сонгууль ажиглах хороонд ирсэн.
- Уг сонгууль ажиглах хороо нь 13 гишүүнтэй үндсэн баг, урт хугацааны 24 ажиглагчдын бүрэлдэхүүнтэйгээр 5 сарын 10-ны өдрөөс эхлэн орон даяар 10 газар байрлан ажиллаж байна.

II. УДИРТГАЛ

Монгол улсын Их Хурал ерөнхийлөгчийн сонгуулийг Үндсэн хуулийн дагуу 2013 оны 6 сарын 26-ны өдөр товловсон. Монгол улсын Гадаад Харилцааны Яамны урилгаар болон 2013 оны 3 сарын 4-8 өдрүүдэд хийсэн Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн багаас гаргасан зөвлөмжийн дагуу ЕАБХАБ-ын АИХЭГ-аас 5 сарын 10-ны өдөр тус сонгууль ажиглах хороог томилов. САХ нь ИБУИНВУ-ын Элчин сайд Одри Гловерын удирдлага дор Улаанбаатар хотод 13 хүнтэй үндсэн баг ажиллах бөгөөд орон даяар 10 байршилд урт хугацааны 24 ажиглагчдыг (УХА) 5 сарын 17–18-ны өдрүүдэд илгээсэн. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилсон сонгууль ажиглах хороог ЕАБХАБ-ын 24 гишүүн орноос бүрдүүлжээ. Дараагийн ээлжинд богино хугацааны 300 ажиглагч сонгуулийн санал хураалт, санал тоолох болон дүн нэгтгэх явцыг ажиглах юм.

III. ҮНДЭСЛЭЛ

2013 оны 7 сард явуулсан УИХ-ын сонгуулийн үр дүнд Ардчилсан Нам (Ерөнхий сайд Н.Алтанхуягийн удирдсан АН), Шударга ёс эвсэл¹ (Ерөнхийлөгч асан Н. Энхбаяр² удирдсан), мөн Иргэний Зориг Ногоон Нам (УИХ-ын гишүүн, Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яамны Сайд С. Оюун удирдсан ИЗНН) хамтран Засгийн Газар байгуулжээ. УИХ дахь нийт 76 суудлаас АН – 34, Шударга ёс эвсэл – 11, ИЗНН – 2 суудал авч, Монгол Ардын Нам (МАН) 1990 оноос хойш анх удаа 26 суудал авч сөрөг хүчинг³ бүрдүүлэв. Хамгийн сүүлд Ерөнхийлөгчийн сонгууль 2009 оны 5 сарын 24-нд болж, АН-аас нэр дэвшигч Ц. Элбэгдорж 51.2 хувийн саналаар Ерөнхийлөгч асан Н. Энхбаярыг ялжээ.

IV. ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА СОНГУУЛИЙН СИСТЕМ

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгууль нь 1992 оны Үндсэн Хууль (1999; 2001 онд нэмэлт өөрчлөлт орсон) 2012 оны 12 сард шинэчлэн баталсан Монгол улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн Хуулийн (МУЕСТХ) дагуу явагдана. Түүнчлэн 2006 оны Сонгуулийн Төв Байгууллагын тухай хууль, Иргэний болон эрүүгийн хуулиуд, Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай, шүүхийн тухай шинэ хууль, тэдгээртэй холбогдох цөөн тооны дүрэм зохицуулалтууд, хууль хэрэгжүүлэх тухай СЕХ-оос гаргасан журмууд хамаарна. МУЕСТХ нь өмнөх хуулиасаа нэлээд ялгаатай, сонгууль эхлэхээс⁴ зургаахан сарын өмнө хэрэгжиж эхэлсэн.

¹ Шударга ёс эвслийг Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН) and Монголын Үндэсний Ардчилсан Нам (МУАН) бүрдүүлдэг.

² 2012 оны 4 сард Авилгатай Тэмцэх Газар Н. Энхбаярыг авилгын хэрэгтэй холбогдуулан баривчлав; Түүнд дөрвөн жил шоронд хоригдох ялыг 2012 оны 8 сард шүүхээс оноов. 2012 оны 12 сард түүний хоригдож буйг МАХН эсэргүүцэн уг эвслийг орхино гэж сүрдүүлж, Энхбаярыг эмнэлэгт шилжүүлжээ.

³ Үүнд бие даан нэр дэвшиж сонгогдсон гурван гишүүн хамаарна.

⁴ Олон улсын тэргүүн туршлагаас харахад сонгуулийн хуулийн гол зарчмыг дараагийн сонгууль болохоос нэг жилийн өмнө өөрчлөх нь зохимжгүй байдаг. Холбоосыг үзнэ үү: Европын Зөвлөлийн Хуулиар Ардчилал тогтоох Европын хороо (Венецийн комисс), Сонгуультай холбоотой тэргүүн туршлага, II.2., [http://www.venice.coe.int/webforms/documents/CDL-EL\(2002\)005-e.aspx](http://www.venice.coe.int/webforms/documents/CDL-EL(2002)005-e.aspx).

ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилсон САХ-той уулзсан зарим хүмүүс уг хуулийг олон нийтээр хэлэлцүүлээгүй хэдий ч хуулийн төслийн ажлын хэсэгт улс төрийн намууд болон СЕХ-ны төлөөллийг оролцуулж, санал, хүсэлтийг хуульд тусгасан гэдгийг хэлж байлаа.

Шинэ МУЕСТХ-д хуульд орхигдсон асуудлууд, тодорхойгүй зүйл заалтууд, ялангуяа сонгуулийн сурталчилгааны талаар хатуу хязгаарлалт бий. Тодорхой бус заалтуудыг СЕХ-оос гаргасан журмаар тодруулах шаардлагатай. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилсон САХ-той уулзсан хүмүүс уг сонгуулийн эрх зүйн орчин ойлгомжгүй хэдий ч сонгуулийн дараа маргаан бараг гардаггүй гэж тодорхойлж байлаа. МУЕСТХ олон талаараа сайжирсан нь сонгууль явуулах эрх зүйн орчинг бүрдүүлэхийн тулд 2010 онд шинэчлэн баталсан УИХ-ын сонгуулийн хуультай холбоотой юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөр дөрвөн жилийн хугацаатайгаар, дээд тал нь хоёр удаа дараалан сонгогдох боломжтой. Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсхүл хорих газар ял эдэлж байгаа иргэнээс бусад бүх иргэн сонгуульд оролцох эрхтэй⁵ ба нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах зарчмаар сонгуульд оролцоно. Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь анхны санал хураалтаар сонгогдохын тулд олонхын саналыг авах шаардлагатай. Хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч сонгуульд оролцсон сонгогчийн 50-иас дээш хувийн санал аваагүй бол хамгийн өндөр санал авсан хоёр дэвшигчдийг хоёр дахь санал хураалтад оруулах ба энэ нь анхны санал хураалт явагдсанаас хойш 14 хоногийн дотор болох ёстой. Хоёр дахь санал хураалтаар нэр дэвшигчийн хэн нь ч олонхын санал аваагүй тохиолдолд сонгуулийг шинээр товлон явуулна. Сонгуулийг хүчинтэйд тооцохын тулд сонгуулийн хэсгийн хороонд сонгогчдын 50-иас багагүй хувь ирж саналаа өгсөн байх ёстой. Ирц хүрээгүй тохиолдолд СЕХ тухайн ирц хүрээгүй сонгуулийн хэсгийн хороонд сонгуульд оролцох эрхтэй ч, санал өгөөгүй сонгогчдоос санал авах талаар шийдвэр гарган, тухайн шийдвэр гарснаас долоо хоногийн дотор нэмэлт санал хураалтыг зохион байгуулна. Нэмэлт санал хураалтаар авсан саналыг өмнөх саналын тоон дээр нэмнэ.

V. СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

Ерөнхийлөгчийн сонгуулийг улсын хэмжээнд СЕХ, Аймаг, Нийслэлийн 22 Сонгуулийн Хороо (АНСХ буюу 21 аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд), сум, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 330 Сум, Дүүргийн Сонгуулийн Хороо (СДСХ), багуудад 1,903 Сонгуулийн Хэсгийн хороо /СХХ/ гэсэн дөрвөн шатлалаар зохион байгуулж, явуулна. УИХ нь 2009 онд СЕХ-ны есөн гишүүнийг төрийн албан хаагчдын дундаас зургаан жилийн хугацаатай томилсон. Хоёр гишүүн нь эмэгтэй юм.

2013 оны байдлаар СЕХ нийт 12 удаа хуралдан дараагийн сонгуультай холбогдуулан 40 гаруй дүрэм, журам, заавар мөн албан ёсны сонгуулийн баримт бичгийн загвар боловсруулан баталжээ. СЕХ бүх шийдвэрүүдээрээ товхимол гарган, тэдгээрийг доод шатны сонгуулийн хороод сонгуулийн өмнө үе ба сонгуулийн өдөр мөрдөн ажиллах талаар САХ-нд мэдээллэсэн. СЕХ нь сонгуулийн нэгж хороодод тохирох зохицуулалт журам хараахан боловсруулаагүй байна.

АНСХ нийт есөн гишүүн (нийслэлд долоон гишүүн), СДСХ, СХХ тус бүр долоон гишүүний бүрэлдэхүүнтэй. Бүх доод шатны сонгуулийн хороодыг хуулинд заасан хугацаанд⁶ багтаан ажиллуулна. Аль ч шатлалын сонгуулийн хороодын гишүүдийг төрийн албан хаагчаас

⁵ Олон улсын стандартын дагуу “Гэмт хэрэгт холбогдсоны улмаас сонгох эрхийг нь түтгэлзүүлбэл оноосон ялын хугацаатай ижил хугацаанд түтгэлзүүлнэ.” НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос 1996 онд гаргасан Иргэний ба Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Хэлэлцээр (ИУТОУХ)-ийн Ерөнхий Тайлбарын 25-ын 14-р хэсэг <http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/0/d0b7f023e8d6d9898025651e004bc0eb>. Гэмт хэрэгт холбогдон шалгуулж буй иргэний хувьд энэ хязгаарлалт хамаарахгүй, сонгох эрхтэй болох тухай ЕАБХАБ-ын САХ судалж, тодрууллаа.

⁶ АНСХ 2013 оны 5 сарын 7, СДСХ 5 сарын 12, СХХ 5 сарын 17-ны өдөр тус бүр байгуулагдсан.

бүрдүүлнэ. Сонгуулийн хороонд Төрийн албан хаагчийг ямар шалгуурыг сонгон ажиллуулах тухай хуулинд тодорхой тусгаагүй байна. СЕХ энэ талаар САХ-нд мэдээлэхдээ хэдийгээр зохицуулах журам байхгүй ч сонгуулийн хороонд ажиллуулахаар сонгон дэвшүүлэхдээ туршлага, тухайн албан хаагчийн 'нэр хүнд'-ийг харгалздаг гэжээ. АНСХ-ны дарга, нарийн бичгийн дарга нарт зориулан СЕХ хоёр өдрийн сургалт зохион явуулахаас гадна АНСХ-ын бусад гишүүд болон СДСХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарыг сургасан нь цааш өргөжин СХХ-ны дарга, нарийн бичгийн дарга нарыг гэх мэтээр тэлж байна.

СЕХ сонгогчдын боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд уг хөтөлбөрөөр сонгуульд санал өгөхийг⁷ уриалан, айл өрх бүрт сонгогч хэрхэн санал өгөх, зөөврийн битүүмжилсэн хайрцагаар санал өгөх талаар зааварчилсан хэвлэмэл хуудас тараан, мөн санал өгөх талаар үндсэн мэдээлэл бүхий хоёр видео клипийг телевизүүдээр цацаж байна. СЕХ-ны өгсөн мэдээллээр сонгогчдод зориулсан болон сонгуулийн мэдээллийг зөвхөн монгол хэл дээр хэвлэх ба бичиг үсэг тайлагдаагүй аль эсвэл монгол хэлээр уншиж чадахгүй хүмүүст⁸ зориулан нэр дэвшигчдийн зургийг оруулна. Мөн СЕХ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн⁹ сонгох эрхээ эдлэхэд туслах зорилгоор ТББ-д санхүүжилт олгоод байна. Сонгуулийн хорооны санал авах байр бүрт харааны бэрхшээлтэй хүмүүст зориулан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас бэлтгэнэ.

Сонгуулийн хорооны санал авах байр тус бүрт сонгогчийг танин баталгаажуулах хурууны хээ уншуулах машин, мөн Санал Тоолох Автомат машин (СТАМ) байрлуулна. СТАМ санал уншуулах, санал тоолох машиныг багтаасан ба сонгуулийн үйл ажиллагаа өндөрлөсний дараа сонгуулийн үр дүнг нэгтгэсэн тайлан хэвлэж гарган улмаар СЕХ руу сонгуулийн дүнг шууд илгээдэг. СЕХ-ны мэдээлснээр сонгуулийн дүнг АНСХ-ны нэгтгэсэн мэдээтэй тулган шалгана. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилсон САХ-той уулзсан зарим хүмүүс СТАМ-ыг найдвартай эсэхт эргэлзэж байна гэв. СТАМ-ыг сонгуулийн өмнө ажиллуулж, туршихаар болов.

VI. СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ

Монгол улсын Үндэсний Иргэний Бүртгэл Мэдээллийн Санд түшиглэн Сонгогчийг бүртгэлийг тодорхой үед хийдэг. Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар (УБЕГ) улсын иргэний бүртгэлийг гүйцэтгэн ээлжит сонгуулийн өмнө сонгогчийн бүртгэлийг электрон хэлбэрт оруулан бэлтгэдэг. Электрон хэлбэрт сонгогчийн бүртгэлийг УБЕГ-ын вэб хуудаст 3 сарын 1-нээс эхлэн хуулийн дагуу олон нийтэд зориулан байрлуулжээ. Мөн 5 сарын 15-ны байдлаар төрийн холбогдох эрх мэдэл бүхий байгууллагууд¹⁰ эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсхүл хорих газар ял эдэлж байгаа, гадаад оронд 60 хоног буюу түүнээс дээш хугацаагаар явсан, мөн цэргийн алба хааж байгаа иргэдийн талаар УБЕГ-т мэдээлжээ. УБЕГ-ын вэб хуудаст 5 сарын 22-ны байдлаар мэдээлснээр сонгууль өгөх эрхтэй сонгогчдын тоо 1,896,382 байгаа ба энэ нь УБЕГ¹¹-ын 3 сарын 1-нд мэдээлсэн 1,902,288 тооноос буурсан байна.

Сонгогчдын урьдчилсан жагсаалтыг СХХ бүрт шинэчлэн сонгогчдын бүртгэлд үндэслэн гаргадаг. Уг жагсаалтыг АНСХ-гоор дамжуулан СХХ-дэд 6 сарын 6-нд хүргэх ба СХХ-ын санал авах байруудад сонгогчид мэдээллээ шалгахад зориулан дэлгэн тавина. Бүртгэлд ороогүй сонгогчид, бүртгэлийн мэдээллийн зөрчилтэй иргэд мөн санал авах өөр байранд сонгууль өгөх

⁷ Сонгуульд санал өгөх урилгад санал авах өдөр, цаг, санал авах байрны хаягийг багтаана.

⁸ 2010 онд хийгдсэн хүн амын тооллогоор үзэхэд Казах иргэд үндэсний хамгийн том цөөнх буюу хүн амын 3.9 хувийг эзэлдэг. Олон ястан амьдардаг аймгуудыг дурьдвал Баян-Өлгий (88.7 хувь Казак), Ховд (хамгийн олон буюу 19 ястангууд), Увс аймагт Ойрд түмэн бий.

⁹ МУЕСТХ-ийн дагуу бүх санал авах байрууд хөгжлийн бэрхшээлтэй иргэд орох боломжтой мөн тэдэнд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан бэлтгэнэ.

¹⁰ Дээд Шүүх, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Газар мөн зэвсэгт хүчин, хил хамгаалах асуудал хариуцсан төрийн бусад байгууллагууд.

¹¹ УБЕГ-ын вэб хуудасны хаяг: <http://www.burtgel.mn/>.

хүсэлтэй сонгогчид харьяа бүртгэлийн хэлтэс, СХХ-д 6 сарын 16 хүртэл бичгээр хүсэлт гаргах боломжтой.

Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар 6 дугаар сарын 25-нд санал өгөх тусгай сонгогчдын жагсаалтыг бэлтгэнэ. МУЕСТХ-ийн дагуу гадаад оронд оршин суугаа Монгол улсын иргэд нь дипломат төлөөлөгчдийн газарт¹² байрлах 39 СХХ-д бүртгүүлж санал өгөх эрхтэй. Хуулиар тогтоосон эцсийн хугацаа болох 5 дугаар сарын 29-ний байдлаар нийт 6,494 сонгогчид хилийн чанадаас санал өгөхөөр бүртгүүлсэн ба 6 дугаар сарын 14-16 өдрүүдэд саналаа өгөх боломжтой.

ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилсон САХ-ны цуглуулсан зарим мэдээллээс үзэхэд түргэн хугацаанд баригдаж буй барилгын ажил, бүрэн бус хаягийн систем, төрийн байгууллагууд хоорондоо мэдээлэл дутуу солилцдоогоос үүдэн шинээр баригдсан барилгууд давхардсан хаягтай байна. Уг байдал нь сонгогчдыг төөрөгдүүлэн, жишээлбэл сонгогчийг буруу бүртгэснээс ирц бүрдэхгүйд хүрэх сөрөг нөлөөтэй байж болзошгүй.

VII. НЭР ДЭВШҮҮЛЭЛТ, БҮРТГЭЛ

Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь сонгууль өгөх эрх бүхий, дөчин таван нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, эцэг эх хоёул¹³ Монгол Улсын харъяат болохыг баталж чадах тус улсын уугуул иргэн байх ёстой. Үндсэн хууль, МУЕСТХ-ийн дагуу зөвхөн УИХ-д суудалтай улс төрийн нам, эвслээс ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй. 1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичгийн 7.5 дахь хэсэгт зааснаас ялгаатай нь ерөнхийлөгчийн сонгуульд хувь хүн бие даан нэр дэвших боломжгүй юм. Энэ удаагийн сонгуульд АН-аас одоогийн Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж, МАН-аас УИХ-ын гишүүн Б. Бат-Эрдэнэ, мөн Монгол улсын түүхэн дахь анхны эмэгтэй нэр дэвшигч, МАХН¹⁴-аас сонгогдсон, Эрүүл Мэндийн Яамны Сайд Н. Удвал тус тус тодров. Гурван нэр дэвшигч МУЕСТХ-д заасан хугацаанд буюу 5-р сарын 14-17 өдрүүдэд СЕХ-д бүртгүүлэн нэр дэвшигчийнхээ үнэмлэхийг 5-р сарын 22-ны өдөр хүлээн авлаа.

VIII. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА

Нэр дэвшигчид¹⁵ СЕХ-ноос нэр дэвшигчийн үнэмлэхийг хүлээн авсан цагаас хойш сонгуулийн сурталчилгааны ажлаа эхлүүлэн 6 дугаар сарын 24-ны шөнө хүртэл сурталчилгааг үргэлжлүүлэх боломжтой. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилсон САХ-ноос хүмүүстэй уулзаж, ярилцахад зарим нь өнөөгийн Ерөнхийлөгч сонгуулийн сурталчилгаагаа өнгөрсөн 4 сард Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Ардчилсан орнуудын 7 дахь удаагийн хуралдаанд оролцох, телевизийн сувгуудаар¹⁶ урт хэмжээний ярилцлага нэвтрүүлэх гэх мэтээр албан ёсны хугацаанаас өмнө

¹² Гадаад оронд түр оршин сууж буй иргэд сонгуульд бүртгүүлэх, оролцох эрхтэй гэж СЕХ мэдээллэв.

¹³ Нэр дэвшигчид тавих шалгуур нь 1990 оны Копенгагены баримт бичгийн 7.3 дахь хэсэгт заасан сонгуулийн эрхийн нийтлэг шалгуурт нийцээгүй ба хязгаарлалт ихтэй байна. Уг баримт бичиг нь ЕАБХАБ-ын гишүүн орнууд “насанд хүрсэн иргэн бүрт нийтлэг, тэгш сонгуулийн эрх” баталгаажуулахыг даалгасан байдаг. Ерөнхий Тайлбарын 25-ын 15 дугаар хэсэгт сонгуульд оролцох эрхийг оршин суух газар, гарал үүслээр шалтгаалан хязгаарлах нь үндэслэлгүй, ялгаварлан гадуурхсан заалт болохыг тодорхойлжээ.

¹⁴ Монголын улс төрд эмэгтэйчүүд харьцангуй төлөөлөл бага байна. Өнөөгийн УИХ-ын 76 гишүүний 11 буюу (14 хувь), Засгийн Газрын 16 гишүүдийн 3 нь эмэгтэй хүн байна. 2012 онд сайжруулсан УИХ-ын Сонгуулийн хуульд хийсэн өөрчлөлтөнд төлөөллийн 20% буюу 28 суудлын хүйсний хэмжээг тогтоосон. ЕАБХАБ-ын САХ-нд Иргэний нийгмийн төлөөлөл илүү үр дүнтэй хувь, шалгуур тогтоохыг эмэгтэйчүүдийн бүлэг дэмжиж байгаа тухай саналаа илэрхийлжээ.

¹⁵ Нэр дэвшигч Н.Удвал сурталчилгаагаа эмнэлэгт эмчлүүлж буй намын дарга Н. Энхбаяртай уулзан эхлүүлсэн бол бусад нэр дэвшигчид сурталчилгааны ажлаа аймгуудаас эхлүүлжээ. САХ-ы УХА-ын мэдээлснээр нэр дэвшигч Ц.Элбэгдорж сонгуулийн сурталчилгаагаа Дорнод аймаг, нэр дэвшигч Б.Бат-Эрдэнэ Хэнтий аймгаас тус тус эхлүүлжээ.

¹⁶ АИСТ, Эйч Ди Монгол, Юү Би Эс, МҮОНТ болон бусад телевизээр 5-р сарын 17-20-ны оргил цагаар уг ярилцлагыг нэвтрүүлсэн. Үүний дараа МАН-ын зүгээс ШӨХТГ болон цагдаагийн газарт сонгуулийн

эхлүүлсэн гэж байв. УИХ-д суудалтай ИЗНН, МҮАН намууд, УИХ-д суудалгүй Эх Орон Нам ба Бүгд Найрамдах Намууд, мөн хоёр алдартай тамирчид¹⁷ одоогийн ерөнхийлөгчийг дэмжиж байна. МАН-ын хувьд 5 дугаар сарын 20-ны өдөр УИХ-д суудалгүй гурван намуудтай¹⁸ хамтран ажиллах санамж бичиг байгуулж, гарын үсэг зурлаа.

Сурталчилгааны үйл ажиллагаа цөөн тооны сурталчилгааны самбарууд, зурагт хуудас, тараах материал, намын сонин гарган Улаанбаатар хот, аймгийн төвүүдэд¹⁹ тараах гэх мэтээр анхаарал бага татах, тайван хэлбэртэй байна. Бүх нэр дэвшигчид орон нутгаар бага хэмжээний уулзалтуудыг²⁰ хийж байна. Тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид зарим аймгуудад өрх бүрт хүрч, мэдээлэл хүргэж буйг САХ ажиглалаа.

Шинэ МҮЕСТХ-ийн дагуу нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, сурталчилгааны амлалт нь Ерөнхийлөгчийн гүйцэтгэх үүрэг хариуцлагын хүрээнд байна. Гурван нэр дэвшигч өөрсдийн вэб хуудаст мөрийн хөтөлбөрөө бүрэн эхээр гаргасан ба тэдгээрт авилгатай тэмцэх, эрх зүйн шинэчлэл, байгаль орчин хамгаалах, уул уурхайн үр нөлөө, хөдөлмөрийн орчныг сайжруулах, эрүүл мэндийн хөтөлбөрийн талаар түлхүү тусгажээ.

Мөн МҮЕСТХ-д сурталчилгаа хийх тэгш боломж олгох, бэлэн мөнгө тараахыг хязгаарлах, төрөл бүрийн санхүүгийн болон ажил олгох амлалтыг зогсоох үүднээс харьцангуй хязгаарласан горим журмыг тогтоосон. Төрийн захиргааны байгууллагын нөөц, соёл, шашин, спортын арга хэмжээг сонгуулийн сурталчилгаанд ашиглахыг хатуу хориглосон. Гүжирдэх, нэр төрийг гутаах, ташаа мэдээ тараахтай холбоотой аливаа үйл ажиллагаа, мөн сонгуулийн өмнө тодорхой хугацаанд олон нийтийн санал асуулгын тандалт хийхийг хоригложээ²¹. Ашгийн төлөө бус, судалгааны үйл ажиллагаа эрхэлдэг Сант Марал Санг 4 дүгээр сард олон нийтийн санал асуулгын судалгааны талаар хэвлэн нийтэлсний төлөө 5 дугаар сарын 2-ны өдөр Шударга Өрсөлдөөн, Хэрэглэгчийн төлөө газраас (ШӨХТГ) арга хэмжээ авч, мөнгөн торгууль оногдуулжээ. ШӨХТГ судалгааны дүнг хэвлэн түгээх нь улс төрийн сурталчилгааны²² нэр төрөл гэж үзжээ.

IX. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

Үндсэн хуулиар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мөн мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулсан байдаг. 1998 оны Хэвлэлийн Эрх Чөлөөний хуулиар төрөөс хяналт тавихыг

сурталчилгааг урьдчилсан хийсэн гэж үзэж гомдол гаргажээ. ШӨХЭХГ уг гомдлыг хэрэгсэхгүй болгосон бол цагдаагийн газар үргэлжлүүлэн шалгаж байна.

¹⁷ Их аварга Д.Дагвадорж, Дархан аварга А.Сүхбат нар АН-д элсэн, гишүүний үнэмлэхээ гардан авсан даруйдаа өнөөгийн Ерөнхийлөгчийг дэмжиж буйгаа олон нийтэд мэдэгдлээ.

¹⁸ Эх орончдын нэгдсэн нам, Ногоон Нам, Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам.

¹⁹ Баян-Өлгий аймагт сурталчилгааны самбар, хуудсыг Монгол-Казак хэл дээр бичсэнийг САХ-оос мэдээллэв.

²⁰ Уулзалтуудыг Дархан-Уул, Дорнод, Хэнтий, Сэлэнгэ, Ховд, Баян-Өлгий, Өмнөговь аймаг, Улаанбаатар хотод гадаа зохион байгуулж байгааг САХ ажиглажээ.

²¹ ШӨХТГ 2013 оны 1-р сарын 1-ний өдрөөс сонгуулийн өдөр хүртэл сонгогчдийн тандан судалгааг хэвлэн нийтлэхийг хориглосон. Хэдийгээр МҮЕСТХ-ийн 33.6 зүйлд сонгогчдийн тандан судалгаа хийх, судалгааны үр дүнг хэвлэх, сонгуулиас долоо хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээхийг хориглодог.

²² ШӨХТГ-аас Сант Марал Санд 1,123,200 төгрөгийн (цалингийн доод түвшинг 8 дахин өсгөсөнтэй ижил; ойролцоогоор 600 орчим евро) торгууль (“Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулиар аль улс төрийн нам хамгийн сайн нэр дэвшигчийг сонгон санал болгох вэ?”, мөн “Монгол улсын Ерөнхийлөгчид хамгийн тохиромжтой хүн хэн бэ?") хоёр асуултын хариулт хэвлэн нийтэлсний төлөө ноогдуулжээ. ШӨХТГ-ын мэдээлсний дагуу уг судалгааны байгууллага МҮЕСТХ-ийн 33.5.4 зүйлийг зөрчсөн (улс төрийн зэрэглэл тогтоох, нэр төрийг гутаах, гүжирдэх, ташаа мэдээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон электрон хэлбэрээр тараах) ба харин 33.6 зүйлийг зөрчөөгүй байна. Тандан судалгааг хийх үед өнөөгийн Ерөнхийлөгчөөс бусад нэр дэвшигчид тодроогүй байсан юм. Уг арга хэмжээний хариуд тус байгууллагаас ШӨХТГ-ыг шинжлэх ухаанд суурилсан судалгаа, сонин буюу цахим хуудасны судалгаа хоорондын ялгааг мэдэхгүй байна гэжээ.

хориглосон. 2005 онд батлагдсан Олон Нийтийн Радио Телевизийн тухай хуулийн дагуу 2005 онд Монголын Үндэсний Телевиз (МҮТ)-ийг Монголын үндэсний олон нийтийн радио телевиз (МҮОНРТ) болон өөрчлөгдсөн. 2001 онд Мэдээллийн Ил Тод Байдал ба Мэдээлэл Авах Эрхийн тухай хууль батлагдсан²³.

Хүний нэр төрд халдан гутаасны²⁴ шийтгэл нь шоронд хорих, цалингийн хамгийн бага түвшинг 60 дахин өсгөсөнтэй тэнцэх торгууль бөгөөд энэ нь сэтгүүлчид ч хамааралтай юм. Эрүүгийн хуулийн төсөлд гутаасан нэр төрийг сэргээх тухай тусгасан бөгөөд үүнийг УИХ авч хэлэлцэнэ. Түүнчлэн, Засгийн Газрын 2013 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн шийдвэрээр интернэтийн орчин дахь “гүтгэлэг, гутаан доромжлол, бүдүүлэг хараал, заналхийлэл”²⁵-ийг хязгаарлах зорилгоор сэтгэгдлийн агуулгыг хянах зохицуулалт хийжээ.

Хэвлэл мэдээллийн өмчлөлийн тухай асуудал хуулиар зохицуулагдаагүй ба ил тод бус байна. Дийлэнх хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сувгууд нь шууд ба шууд бус байдлаар улс төрийн нам хүчинд харьяалагддаг гэж хэвлэл мэдээллийн шинжээчид үзжээ. Ингэснээр редакцийн хараат бус байдал алдагдахад хүрчээ. Энэ байдал нь хэвлэл мэдээллийн хүчийг сааруулж, мэдээлэл хэрэглэгчдийг дүгнэлт гаргах боломжгүй болгож байна. Гэсэн хэдий ч хэвлэл мэдээллийн зах зээл нь улс төрийн олон тал байдлыг тодорхой түвшинд байлгаж байгаа юм байна гэж шинжээч үнэллээ.

МҮЕСТХ, түүнийг хэрэгжүүлэх тухай СЕХ, ХХЗХ-ноос 4 дүгээр сарын 5-нд гаргасан хамтарсан тогтоолоор сонгуулийн сурталчилгааны үед үнэгүй сурталчилгааны цаг нэр дэвшигч бүрд тэнцүү олгохыг МҮОНРТ-д зөвшөөрсөн.

Түүнээс гадна МҮЕСТХ арилжааны телевизийн сувгуудаар төлбөртэй цацах сурталчилгааны цагийг хоногт нэг цагаас илүүгүй байхаар хязгаарлажээ. Мөн хэвлэл мэдээллээр цацах сурталчилгааны агуулгад хариуцлагыг тогтоон сурталчилгааны үеэр улс төрд оролцогчдын талаар гүтгэлэг, ташаа мэдээлэл түгээхийг бүрэн хоригложээ. Хэрэв тогтоосон хууль, дүрмийг зөрчсөн тохиолдолд тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааны эрхийг гурав хүртэл сараар түтгэлзүүлнэ. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй²⁶ холбоотой хуулийн зүйл заалтын хэрэгжилтийг хянаж ажиллахыг анх удаа ШӨХТГ-д даалгажээ.

Эрх зүйн тогтолцоо нь сурталчилгааны зорилгоор хэвлэн нийтлэх үйл ажиллагааны хүрээг бүрэн тодорхойлоогүй байна. Сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө МҮОНРТ нь СЕХ-нд хандан холбогдох шийдвэрт тусгасан “зөрчилдсөн зааварчилгаа”²⁷-ны талаар тодруулах тухай бичгээр хүсэлт гаргажээ. Мэдээллийн хөтөлбөрөөр сурталчилгааны мэдээлэл нэвтрүүлж болох эсэхийг уг хүсэлтэд лавлажээ. МҮОНРТ-д мэдээллийн хөтөлбөрөөр сурталчилгааны мэдээлэл нэвтрүүлэх нь холбогдох шийдвэрийг зөрчихгүй болох талаар амаар хариу авсан тухай САХ мэдээлэл авсан хэдий ч СЕХ мэдээний цагаар сонгуулийн сурталчилгааг мэдээллэх нь хуулиар яаж зохицуулагдсаныг албан ёсоор мэдэгдээгүй байна.

²³ Үндсэн хууль, Мэдээлэл хүлээх авах тухай хуулийн улсын нууцад хамаарахаас бусад зарим зүйл, заалтын дагуу мэдээлэл авах эрхтэй “улсын нууц хэмээн хамгаалагдсанаас бусад мэдээлэл” юм.

²⁴ 2011 оны 3 сард ИУТОУХ-ийн талаар Монгол улсын Засгийн Газраас гаргасан тайланд үндэслэн НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос зөвлөмж болгох нь. Дараах хаягаас үзнэ үү. http://ccprcentre.org/doc/HRC/Mongolia/CCPR.C.MNG.CO.5_en.pdf.

²⁵ Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос хэрэглэхийг хориглосон үгсийн жагсаалт гаргана.

²⁶ Өрсөлдөөний тухай хуулийн 17.2 заалт ШӨХТГ-ын есөн гишүүний зургааг (дарга, 2 орон тооны ба 3 орон тооны бус) Ерөнхий сайд томилно. Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Үйлдвэрчний Эвлэл, ТББ-ууд ажилчдын эрх ашгийг хамгаалах бөгөөд тус бүр нэг орон тооны бус гишүүнийг нэр дэвшүүлэн, Засгийн Газраар баглуулна.

²⁷ МҮОНРТ-ийн зүгээс мэдээллийн хөтөлбөрөөр нэвтрүүлж болохгүй “сонгуулийн сурталчилгаа” гэдэг ойлголт (нэмэлт журмын 2.2 заалт), “сонгуулийн сурталчилгааны мэдээ” гэсэн ойлголт улс төрийн сурталчилгаанд орох эсэх (2.4 заалт), “сонгогчдийн саналд нөлөө үзүүлж болзошгүй” нэвтрүүлгийн тодорхойлолт (3.19 заалт) зэргийг тодруулахыг хүссэн.

САХ 5 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн телевизийн 5 суваг, өдөр тутмын 4 сонинд²⁸ тоон болон чанарын хяналтыг гүйцэтгэж байна.

Х. ӨРГӨДӨЛ ГОМДОЛ

МУЕСТХ нь өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл ажиллагааг нарийн тодорхойлоогүй мэт боловч ба уг ажиллагаа нь шат дараалсан хариуцлага тооцох зарчимтай. Уг ажиллагаанд хэд хэдэн төрлийн шүүх, төрийн тохируулагч байгууллагууд оролцдог. СЕХ нь сонгох эрх зөрчигдсөн талаар бус харин сонгуулийн нэгж хороодын үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийг шийдвэрлэх эрхтэй.

МУЕСТХ-ийн дагуу ажил үүргээ гүйцэтгэх явцдаа сонгуулийн хороодын гишүүд уг хуулийг зөрчсөн тохиолдолд хууль зөрчигдсөд иргэний ба эрүүгийн хариуцлага хүлээлгэх, мөнгөн торгууль ногдуулах, эсвэл хамгийн багадаа нэг жилээр²⁹ ажлаас халах зэрэг заалтуудаар зохицуулжээ. Сонгуулийн хорооны шийдвэрийн талаарх гомдлыг дээд шатны сонгуулийн хороонд гаргаж болох ба ийн хандсан тохиолдолд асуудлыг дээд шатны сонгуулийн хороо гурав хоногийн дотор шийдвэрлэх ёстой. СЕХ-ны эцсийн шийдвэр нь ажил олгогч төрийн байгууллагын сонгуулийн хорооны гишүүнийг ажлаас нь халах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх ба ажлаас халсан шийдвэрийн талаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэх шүүхэд гомдол гаргах боломжтой. Сонгогчийн бүртгэлтэй холбоотой гомдлыг харьяа иргэний бүртгэлийн алба хариуцах ба УБЕГ-ын шийдвэрийн талаар гомдолтой тохиолдолд мөн захиргааны хэргийг хянан шийдвэрлэх шүүхээр шийдвэрлүүлэх боломжтой.

МУЕСТХ-ийн дагуу бусад бүх төрлийн гомдол, зөрчлийг цагдаагийн байгууллага мөрдөн шалгаж, хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан иргэн, захиргаа, эрүүгийн хэргийн шүүхээр хянан шийдвэрлүүлнэ. Сонгуультай холбоотой маргаан, гомдлыг шүүхээр шийдвэрлэхэд тодорхой хугацаа заагаагүй байдаг бөгөөд зөвхөн санал худалдан авах, сонгуулийн хайрцгийг хуурамч саналаар дүүргэх (энэ хоёр хэрэгт 3-6 сар шоронд хорих ял оноодог) гэх мэт эрүүгийн хэргийн хувьд мөрдөн шалгах ажиллагааг түргэсгэн хянан шийдвэрлэх эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохицуулалттай. МУЕСТХ-ийн дагуу зөрчлийг шийдвэрлэх албан тушаалтан нь зохих шийдвэрийг хэргийн байдлаас шалтгаалан цаг алдалгүй шийдвэрлэх үүрэгтэй.

Үндсэн хуулийн цэцийн 2005 оны шийдвэрээр СЕХ-ны шийдвэр, тогтоолыг захиргааны хэргийн шүүх хянах эрхгүй болж, зөвхөн Үндсэн хуулийн цэц хянадаг болсон. Захиргааны хэргийн шүүх нь СХХ, СДСХ, АНСХ-ны шийдвэртэй холбоотой хэргийг шүүн шийдвэрлэх боловч хууль зөрчсөн үйл ажиллагааг таслан зогсоохыг шаардах, зогсоогоогүй бол шийтгэл ногдуулах эрхгүй.

Одоогийн байдлаар СЕХ-нд хоёр гомдол ирсэн тухай мэдээллийг САХ аваад байна. Нэг нь Баян-Өлгий аймаг дахь МАН-ын төлөөллийг аймгийн сонгуулийн хороонд оролцуулаагүй гэсэн гомдол байсан. Дараах гомдол нь хувь хүн Ерөнхийлөгчийн сонгуульд бие даан нэр дэвших талаар байв. Хоёр гомдлын хариуг СЕХ бичгээр мэдэгдсэн ажээ. Нэгдүгээр гомдлын хувьд уг асуудлыг хуучин хуулийн заалтын дагуу гаргасан ба шинэ хуулийн дагуу гомдол нь үндэслэлгүй болох тухай, дараагийн гомдолд Үндсэн Хууль болон МУЕСТХ-ийн аль алинд зөвхөн УИХ-д суудалтай улс төрийн нам, эвслээс ерөнхийлөгчид нэр дэвшүүлэхийг зөвшөөрдөг тухай хариу мэдэгдэн хүргүүлсэн байна.

МАН-ын зүгээс СЕХ, ШӨХТГ, цагдаагийн газарт хүргүүлсэн хэд хэдэн гомдол, шаардлагын тухай мэдээллийг САХ-нд өгөөд байна. Үүнд өнөөгийн Ерөнхийлөгч сурталчилгааныхаа үеэр МУЕСТХ-ийг зөрчсөн санхүүгийн шинжтэй амлалт өгсөн тухай гомдол багтжээ.

²⁸ Хэвлэл мэдээллийн мониторингийн хүрээнд МҮОНТ, Ийгл ТВ, ТВ5, ТВ9, UBS мөн Өдрийн сонин, Үнэн, Өнөөдөр, Зууны Мэдээ өдөр тутмын сонин хамрагдана.

²⁹ Сонгуулийн хорооны дарга нь Төрийн албаны тухай хуульд захирагдана.

XI. ИРГЭД БА ОЛОН УЛСЫН АЖИГЛАЛТ

МУЕСТХ-ийн дагуу дотоодын болон гадаадын ажиглалт хийгддэг. Улс төрийн нам, эвсэл, ТББ-ын зүгээс 4 хүнийг төлөөлүүлэн СХХ-нд ажиглалт хийлгэх эрхтэй. Хэрэв санал авах байранд бүх ажиглагчдыг оролцуулах боломжгүй тохиолдолд СХХ нь байгууллага бүрээс хамгийн багадаа хоёр ажиглагчийг ажиллах боломж олгоно. СЕХ дотоодын ажиглагчдыг сонгуулийн өдрөөс гурав хоногийн өмнө бүртгүүлж эрх авсан байх талаар САХ-нд мэдэгджээ. Энэ удаагийн сонгуулийг 500 орчим гадаадын, ойролцоогоор 1,900 дотоодын ажиглагчид, мөн 2012 оны сонгуульд ажиглалт хийсэн “Шударга сонгуулийн төлөө” зургаан иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн сүлжээ ажиглалт хийн оролцоно. СЕХ дотоод, гадаадын ажиглагчдын эрх, үүрэг хариуцлага мөн ажиглалт хийх эрх олгох талаар журмыг 3 дугаар сарын 27-ны өдөр баталсан байна.

XII. ЕАБХАБ/АИХЭГ-аас томилсон САХ, түүний үйл ажиллагаа

САХ үйл ажиллагаагаа 2013 оны 5 дугаар сарын 10-ны өдөр эхлүүлж 5 дугаар сарын 13-ны өдөр хэвлэлийн хурал хийн энэ тухай танилцуулжээ. Тус хорооны дарга СЕХ-ны дарга, Гадаад Хэргийн Дэд Сайд, УИХ-ын гишүүд, Үндэсний Хүний Эрхийн Комисс, Үндсэн Хуулийн Цэц, Дипломат албаны төлөөлөгчидтэй уулзав. САХ-ны зүгээс СЕХ, сонгуулийн үйл ажиллагаанд оролцдог төрийн байгууллагууд, улс төрийн нам, эвслүүд, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай харилцаа тогтоолоо. Харин нэр дэвшигчидтэй уулзалт хийгээгүй байна. ЕАБХАБ-ын гишүүд ба хамтран ажилладаг түнш орнуудын дипломат төлөөлөгчдийн анхны уулзалт 5 дугаар сарын 31-нд зохиогдсон.

Энэхүү тайлангийн Англи хэл дээрх хувилбар нь албан ёсны хувь юм. Монгол хэл дээрх нь албан бус орчуулга болно.